



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/54

Баянхутаг сум

**АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 44 дүгээр зарлиг, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 9/947 албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын хаврын “Мод тарьж ургуулах аян” өрнүүлэхтэй холбоотой ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Наранбадрал – Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Л.Энхцэцэг – Байгаль орчны улсын байцаагч

Гишүүд: Д.Буянбат – Жаргалант багийн Засаг дарга

Д.Алтанчимэг – Улаан-Өндөр багийн Засаг дарга

Б.Алтангэрэл – Цантын хоолой багийн Засаг дарга

Г.Ганболд – ЕБС-ийн захирал

Т.Наранцэцэг – Цэцэрлэгийн эрхлэгч

С.Мөнххэрлэн – Соёлын төвийн дарга

Ц.Ганзориг – ЭМТөвийн эрхлэгч

2. Тэрбум мод үндэсний хөдөлгөөн хэрэгжүүлэх аяны хүрээнд 05 дугаар сарын турш “Мод тарьж, ургуулах аян” өрнүүлж, тэрбум мод тарих үндэсний өдрийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулах, мод тарих, иргэдэд сурталчлан таниулж ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга /С.Наранбадрал/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЙГАЛМАА



232501054